



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/259

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IV.2.1-д "Төрийн байгууллагуудын засвар, тоног төхөөрөмж"-д батлагдсан 500.0 сая төгрөгөөс санхүүжигдэх Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын автомашины шинэчлэл 40.0 сая төгрөг, Хайрхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын автомашины шинэчлэлд 40.0 сая төгрөг, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын автомашины шинэчлэлд 40.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг дээрх сумдын Засаг дарга нарт шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100570